



ЖИЛИЙН ТАЙЛАН 2023



АРИГ БАНК

Шинэ цагийн шилдэг банк болохын тулд харилцагчаа дээдэлж, үйлчилгээгээ цахимжуулж, хүртээмжтэй шинэ шинэлэг, харилцагчийн хүсэл хэрэгцээг шийдсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд анхаарна.

Ариг банк нь одоогийн зорилго, зорилтоо шинэчилж, финтект суурилсан мерчантын хөнгөлөлттэй зээл, хувь хүний зээлийн үйлчилгээ зэргийг үзүүлэх замаар худалдаа арилжааны салбарт дижитал банк болохыг зорин ажиллаж байна.

Агуулга

Эрхэм зорилго, Хэтийн зорилт.....	04
Бидний үнэт зүйлс.....	05
Байгууллагын танилцуулга.....	06
ТУЗ-ийн даргын мэндчилгээ.....	08
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.....	09
Төлөөлөн удирдах зөвлөл.....	10
Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ.....	14
Бүтэц, зохион байгуулалт.....	16
Удирдлагын баг.....	18
Хараат бус аудитын тайлан.....	20
Санхүүгийн үзүүлэлтүүд.....	28
Нийгмийн хариуцлага	30
Дижитал банк.....	32
Хүний нөөцийн үйл ажиллагаа.....	34
Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ.....	36
Эрсдэлийн удирдлага.....	38
Олон улсын харилцааны чиглэлээр.....	39
Салбар нэгжийн мэдээлэл.....	42



Алсын хараа

Худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох



ЭРХЭМ ЗОРИЛГО

Ухаан, Хүсэл, Уран сэтгэмж
Улам шинэлэг хамт олноороо
Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх
банк

ХЭТИЙН ЗОРИЛТ

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний
цахим болон биет сувгийн оновчтой
хослолоор харилцагчиддаа
бүтээгдэхүүн үйлчилгээгээ
хүргэдэг, харилцагчийн гайхалтай
үйлчилгээтэй, нийгмийн
хариуцлагаараа манлайлагч банк
болох

Бидний үнэт зүйлс

ХҮМҮҮС

Сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй

БҮТЭЭГДЭХҮҮН

Амдуулан бодсон, Амьдралаас үүдсэн

ҮЙЛ ЯВЦ

Шуурхай, Найдвартай, Саадгүй

ОРЧИН

Зочломтгой, Тухтай, Халамжтай



Бидний тухай

Монгол Улсын банк санхүүгийн зах зээлд 27 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй Ариг банк Улаанбаатар хот дахь 16, Дархан-Уул аймаг дахь 3, Орхон аймаг дахь 1, нийт 19 салбар нэгж, дижитал сувгаараа дамжуулан харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг шуурхай хүргэж байна.

Ариг банк Монгол улсад 2 шатлал банкны систем үүсэн 7 дах жилд буюу 1997 онд Эрэл банк нэртэйгээр үйл ажиллагаа явуулах эрхээ авснаар эх түүхээ бүтээж эхэлсэн. Харин 2014 онд брэндийн шинэчлэлээ хийж, нэрээ тунгалаг ариун байхын билэгдэн Ариг банк болгон өөрчилсөн билээ. Улмаар “Номин Холдинг” ХХК нь 2018 оноос эхлэн Ариг банканд үе шаттай хөрөнгө оруулж, дүрмийн санг нэмэгдүүлэн, менежмент, засаглалыг сайжруулснаар өдгөө Монголбанкны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна. Үүсгэн байгуулагдсанаас хойш 27 жилийн хугацаанд бид шуурхай, найрсаг үйлчилгээ, уян хатан нөхцөлтэй бүтээгдэхүүн цаг зав хэмнэсэн шинэчлэлүүд, тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил, санаачлагаараа харилцагчид, хөрөнгө оруулагчид, түншүүдийнхээ итгэлийг хүлээсээр ирлээ.

Ариг банк харилцагчдынхаа хэрэгцээ сонирхол, амьдралын хэв маягт нийцсэн инновац, шийдлүүдийг нэвтрүүлэн, харилцагч төвтэй байж, санхүүгийн цогц үйлчилгээг хялбар, хүртээмжтэйгээр хүргэж, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэхийг эрхэмлэн зорьж байна.

НИЙТ ХАРИЛЦАГЧИЙН ТОО	ХАРИЛЦАХ ДАНС ЭЗЭМШИГЧ	ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ
73,351	43,485	10,993
ИНТЕРНЭТ БАНК ХЭРЭГЛЭГЧ	КАРТ ЭЗЭМШИГЧ	ПОС ЭЗЭМШИГЧ
21,068	7,565	788
САЛБАР, ТООЦООНЫ ТӨВ	НИЙТ АЖИЛТНЫ ТОО	ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО
17	264	5,290

ТУЗ-ийн даргын мэндчилгээ



Хүндэт харилцагчид, ажилтнууд,
хувьцаа эзэмшигчид ээ,

Юуны өмнө Ариг банкны ТУЗ-ийн нэрийн өмнөөс Ариг банкаар итгэн үйлчлүүлж буй харилцагч, хадгаламж эзэмшигч нартаа болон банкны үнэт капитал болсон нийт ажилтнууд, хамтран зүтгэгч нарын банкныхаа төлөө гаргаж буй хөдөлмөр, хичээл зүтгэл, ирээдүйд итгэж буй итгэл сэтгэлд талархаж байгаагаа илэрхийлье!

Ариг банкны хувьцаа эзэмшигчдийн зүгээс болон төлөөлөн удирдах зөвлөлөөс удирдлагын багийг банкны салбарын арвин туршлагатай, мэргэжлийн хүмүүсээр бүрдүүлэн банкны менежментийг удирдан чиглүүлж ажиллаа. Энэхүү өөрчлөлт үр дүнгээ өгч Ариг банкны санхүүгийн үзүүлэлт сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 100 тэрбум төгрөгөөр нэмэгдэж,

нийт актив хөрөнгийг өмнөх оны мөн үеэс 169%-иар өсгөж, 2023 онд 440 тэрбум төгрөгт хүрлээ.


Ариг банк түүхэндээ анх удаагаа Монгол Улсын засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас хамтран жил бүр уламжлал болгон тодруулдаг "Монгол Улсын Топ-100 аж ахуйн нэгж"-ээр шалгарсан нь банкны хурдацтай өсөлтийн нэг илэрхийлэл юм.

Мөн банкны эрчимтэй өсөлтөд үе шаттай хөрөнгө оруулалтыг хийж Монголбанкны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллах боломжийг бүрдүүлсэн хувьцаа эзэмшигч нартаа талархаж байна.

2023 онд Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төлөвлөгөө хүргүүлэх, тайлагнах, хянах журам"-д заасны дагуу банкныг хаалттай хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах зөвшөөрлийг Монголбанкнаас авч компанийн дүрмийг шинэчлэн баталлаа.

Цаашид бид худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох үндсэн зорилтын хүрээнд технологийн чиглэлд тасралтгүй хөрөнгө оруулалт хийж харилцагчдын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах, өсөлтийг хадгалсан, үйлчлүүлэгч харилцагчаа дээдэлж хамтдаа өргөжин тэлсэн жил байхыг зорин ажиллах болно.

Та бүгдийн ажил үйлс, хөдөлмөрт тань өндөр амжилт хүсье.


Хүндэтгэсэн: **Ариг банкны ТУЗ-ийн дарга,
хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнэ**

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

78.84%


УЛААНБААТАР ИМПЕКС ХХК

"Ариг Банк" ХХК-ийн толгой компани ба банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулахад төвлөрч ажиллаж байна. Ариг банкны энгийн хувьцааны 78.84 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 73.18 хувийг иргэн Ш.Баярсайхан, 26.82 хувийг "Номин реалтор" ХХК эзэмшдэг.

21.16%

ДЭМ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

"Ариг Банк" ХХК-ийн толгой компани бөгөөд банк, санхүүгийн салбарт голлон төвлөрч ажилладаг. Ариг банкны энгийн хувьцааны 21.16хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 100%-ийн хувьцааг иргэн Б.Эрдэнэбат эзэмшдэг.



Төлөөлөн удирдах зөвлөл



П.Мөнх-эрдэнэ

ТУЗ-ийн дарга, хараат
бус гишүүн



С.Сайнбат

ТУЗ-ийн гишүүн



Ш.Баярсайхан

ТУЗ-ийн гишүүн



Я.Наваан

ТУЗ-ийн гишүүн



Н.Цэрэндаваа

ТУЗ-ийн хараат бус
гишүүн



Д.Чимид-Юндэн

ТУЗ-ийн гишүүн



С.Хосбаяр

ТУЗ-ийн гишүүн



Д.Түвшинтамир

ТУЗ-ийн хараат бус
гишүүн



Б.Ариунжаргал

ТУЗ-ийн гишүүн



Я.Нацагдорж

ТУЗ-ийн Нарийн
бичгийн дарга




Г.Тэмүүжин

ТУЗ-ийн дэргэдэх
Дотоод аудитын газрын
захирал

Төлөөлөн удирдах зөвлөл

“Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд дараах бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.



ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх үүднээс Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин, урамшууллын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо, Мэдээллийн технологийн хороо зэрэг нийт 5 хороотой бөгөөд хороод нь ТУЗ-өөс баталсан тус бүрийн нарийвчилсан дүрмээр зохицуулагддаг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ариг Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, үүнд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журам, заавар, Ариг Банкны дүрэм, Компанийн Засаглалын Кодекс болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон журам тогтоомж, дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай биелүүлж ажиллахыг чиглэлээ болгодог.

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь Банкны хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Банкны ТУЗ-ийн дарга болон гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагад ажилладаггүй болно.

ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх, үүрэг зэрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагдах бөгөөд хуульд заасны дагуу ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн Дарга зарлаж хуралдуулна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг хөтлөн, гарын үсгээр баталгаажуулж хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигч нар болон Монголбанканд хүргүүлэн ажилладаг.

Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэгт холбогдох хороод нь эрх, үүргийн дагуу хяналт тавин ажилладаг болно.

ТУЗ нь банкны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахаар зохион байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх эрхийг банкны Хувьцаа эзэмшигч нар эдэлнэ /Хараат бус гишүүнийг Монголбанкны зөвшөөрснөөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ/.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

1.1 Эрсдэлийн удирдлагын хороо:

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг. Үүнд:

- Эрсдэлийн аппетитын бодлого, эрсдэлийн лимит, эрсдэлийг удирдах стратеги, зээлийн бодлого, комплаенсын бодлого, засаглалын кодексын бодлогын баримт бичгийг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д гаргах, Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх чиг үүрэг өгч, хянах
- Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, топ эрсдэлүүд болох зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн, мэдээлэл технологийн болон бусад төрлийн эрсдэлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавих, чиглэл өгөх
- Гүйцэтгэх удирдлагын Эрсдэлийн удирдлагын газрын тайланг хэлэлцэх, хянах
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Банкны баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтийг хянах ба энэ талаарх үйл ажиллагааны улирлын тайланг хянах
- Санхүүгийн хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулах, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах үүрэгтэй бөгөөд ТУЗ-д зохистой өөрчлөлт оруулах талаар санал гарган ажиллана.

№	Овог, нэр	Албан тушаал
1	Б.Ариунжаргал	Хорооны дарга, ТУЗ-ийн ердийн гишүүн
2	Д.Түвшинтамир	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн
3	Д.Чимэд-Юндэн	Хорооны гишүүн, ТУЗ-ийн ердийн гишүүн

1.2 Аудитын хороо:

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг. Үүнд:

- Банкны санхүүгийн үнэн зөв, бүрэн бүтэн тайлагнал, санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд болон эрх зүйн бусад актуудтай нийцэж байгаа эсэхийг хянах,
- Дотоод аудитын хараат бус байдлыг хангах, төсвийг батлах, удирдах аудитын хүрээ, давтамжийг тогтоох, тайланг хэлэлцэх, гүйцэтгэлийг хянах,
- Дотоод аудиторыг сонгон шалгаруулах, томилох, ажлаас чөлөөлөх, цалин, урамшууллыг тогтоох,
- Банканд хийгдэх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, өөрчлөх, үйл ажиллагааг хянах, гүйцэтгэлийг үнэлж холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлэх
- Банкны Зөрчлийг мэдээлэх (шүгэл үлээх) үр дүнтэй тогтолцооны хэрэгжилтийг хянах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
- Аудитын дүгнэлтэд дурдсан банкны дотоод хяналтын тогтолцооны сул талууд, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжийн дагуу тохиромжтой цаг хугацаанд хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй.

№	Овог, нэр	Албан тушаал
1	Д.Түвшинтамир	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
2	Н.Цэрэндаваа	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн
3	С.Хосбаяр	Хорооны гишүүн, ТУЗ-ийн ердийн гишүүн

1.3 Мэдээллийн технологийн хороо:

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг. Үүнд:

- Банкны мэдээллийн технологийн бодлого, стратеги, стандарт зэрэг бодлогын баримт бичгийг хэлэлцэж батлах, Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэлтийн чиг үүрэг өгөх, хяналт тавих
- Мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэж буй ажлын тайлан хэлэлцэх
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стратеги, стандарт зэрэг бодлогын баримт бичгийг хэлэлцэж батлах, олон улсын стандарт хангаж буй эсэхэд хяналт тавих, Гүйцэтгэх удирдлагад чиг үүрэг өгөх, хяналт тавих
- Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хийгдэж буй ажлын тайлан хэлэлцэх
- Банкны дижитал шилжилт, технологийн давуу тал ашиглаж буй эсэхэд хяналт тавих, ажлын тайлан хэлэлцэх, үүрэг чиглэл өгөх

№	Овог, нэр	Албан тушаал
1	Н.Цэрэндаваа	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
2	Я.Наваан	Хорооны гишүүн, ТУЗ-ийн ердийн гишүүн
3	С.Сайнбат	Хорооны гишүүн, ТУЗ-ийн ердийн гишүүн

1.4 Цалин, урамшууллын хороо:

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд ТУЗ-д шаардлагатай асуудлуудаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлдэг. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох, гишүүдийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банканд үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх,
- Банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэх
- Банкны цалин урамшууллын бодлого, чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, гүйцэтгэлд суурилсан системээр урамшуулан хөгжүүлэх замаар банкны бизнесийн зорилго, зорилтод хүрэх, тогтвортой бизнесийн хөгжил авчрахад дэмжлэг үзүүлэх
- Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянаж, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгөх,
- Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллыг тогтоох

- Гүйцэтгэх захирал ба гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх тус тус үүрэгтэй ажилладаг.

№	Овог, нэр	Албан тушаал
1	Ш.Баярсайхан	Хорооны дарга, ТУЗ-ийн ердийн гишүүн
2	Н.Цэрэндаваа	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн
3	П.Мөнх-Эрдэнэ	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн

1.5 Засаглал, нэр дэвшүүлэх хороо:

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд Хувьцаа эзэмшигч, ТУЗ-д шаардлагатай асуудлуудаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлдэг. Үүнд:

- ТУЗ гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах
- Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх тухай ТУЗ-д санал, зөвлөмж өгөх,
- Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах зэргээр ажилладаг.

№	Овог, нэр	Албан тушаал
1	Я.Наваан	Хорооны дарга, ТУЗ-ийн ердийн гишүүн
2	Д.Түвшинтамир	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн
3	П.Мөнх-Эрдэнэ	Хорооны гишүүн, ТУЗ-ийн хараат бус гишүүн

Дотоод аудит

Дотоод аудит нь банкны Эрсдэлийн удирдлага, Хяналтын тогтолцоо, Засаглалын аливаа үйл ажиллагааны үр өгөөжтэй байдлыг системтэйгээр үнэлж дүгнэн, байгууллагын өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд нь тусалдаг бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагаа бөгөөд Ариг банкны дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн харьяа Аудитын хороо түүний дэргэдэх Дотоод аудитын газар хариуцан ажиллаж байна.

Дотоод аудитын газар нь үйл ажиллагаагаа банкны Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар явуулдаг бөгөөд банкны үйл ажиллагааг сайжруулах үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой, хараат бус, бодитой баталгаажуулалт хийх, зөвлөмж, зөвлөгөө өгөхөд чиглэн ажилладаг. Дотоод аудитын газар нь Дотоод аудиторудын олон улсын институт (IIA)-ийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework), олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа жишиг болгон ажилладаг.

Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд, хамтран ажиллагсад аа,

Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон банк санхүүгийн хөгжилтэй хөл нийлүүлэн хурдацтайгаар өргөжин тэлж 27 дах жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй Ариг банкны 2023 оны ажлынхаа үр дүн, тайланг танилцуулж байна.

2023 он Монгол улсын эдийн засаг 5.4 хувийн өсөлттэй гарлаа. Үүнийг дагаад банкны салбарын үзүүлэлт тогтвортойгоор өсөж нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар нэмэгдсэн байна. Ингэж өсөхөд макро орчны таатай нөхцөл уул уурхайн салбар түүнийг дагасан тээвэр логистикийн сэргэлт харьцангуй хурдацтай сэргэж, худалдаа үйлчилгээний салбарын 7 хувийн өсөлт зэрэг нь эерэгээр нөлөөллөө. Мөн оны эхнээс хугацаагүй хадгаламжид хүү тооцож эхэлсэн нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн юм.

Эдийн засаг, санхүүгийн өсөлттэй энэ үед Ариг банкны менежментийн баг оновчтой зөв шийдвэрүүдээр баг хамт олноо чиглүүлэн ажилтнуудынхаа хүчин чармайлт, харилцагчдынхаа итгэлийн үндсэн дээр 2023 онд санхүүгийн үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад нийт актив 167 хувиар өсөж 445 тэрбум төгрөгт, нийт цэвэр зээлийн үлдэгдэл 193 хувиар өсөж 195,4 тэрбум төгрөгт, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 199 хувиар өсөж 332 тэрбум төгрөгт хүрч 17.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оноосоо 131.1 хувиар өсгөсөн үзүүлэлт бөгөөд чанаргүй зээлийг 12.3 тэрбум төгрөгт болгож 2022 оны эцэстэй харьцуулахад 6.4 тэрбум төгрөг буюу 34.4%-иар буурууллаа.

Ариг банкнаас харилцагч үйлчлүүлэгчдээ үйлчилгээг ойртуулах үүднээс 2023 онд Орхон аймагт шинэ салбараа нээснээс гадна Улаанбаатар хотод 3 салбарыг шинээр нээж, 4 салбарын байрлалыг үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөнтэй уялдуулан шилжүүлж, банкны



стандартын дагуу 6 салбарт бүрэн засварыг хийлээ.

Мөн худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох зорилтынхоо цахим үйлчилгээнүүддээ шинэ шинэчлэлт хөгжүүлэлтийг үе шаттайгаар хийж ирлээ. Ариг онлайн аппликейшн гаргаж онлайн цалингийн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн нь харилцагч үйлчлүүлэгчдийн цаг хугацааг хэмнэсэн эрэлт хэрэгцээ ихтэй бүтээгдэхүүн боллоо. Үүнээс гадна бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд, Алт барьцаалсан зээл, Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан эргэлтийн хөрөнгийн зээл, Монгол банк, Засгийн газар, Сангийн яам, Хөдөө аж ахуйн яамтай хамтран хэрэгжүүлэх хүүгийн хөнгөлөлтэй нөхцөл бүхий Хөдөө аж ахуйн зээл, Авто машин барьцаалсан шуурхай зээл, Ханган нийлүүлэгчдийн зээл, Харилцагчийн сегмент бүрд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээний багцыг бий болгож, төрөлжүүлэх хүрээнд Ханган нийлүүлэгчийн багц бүтээгдэхүүнийг шинээр гаргаж, Энгийн хугацаатай хадгаламжийг хоногийн хугацаатай болгон бүтээгдэхүүнээ шинэчлээ.


Бид цаашид хөрөнгө оруулагчдынхаа өгөөжийг нэмэгдүүлэх, харилцагч үйлчлүүлэгч, түншүүдийнхээ итгэлийг хүлээж, хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлсэн, харилцагчийн үйлчилгээг дээдэлсэн, цахим үйлчилгээнд тулгуурласан, худалдааны салбарыг түшиглэсэн банк болох зорилтыг барин ажиллаж Монгол улсын банк санхүүгийн систем эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэхэд чармайн ажиллах болно. Бидэнд өндөр итгэл үзүүлэн үйлчлүүлдэг эрхэм харилцагч, үйлчлүүлэгч, түншүүд болон бидний шийдвэрийг үргэлж дэмжин ажилладаг Төлөөн Удирдах Зөвлөл, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч та бүхэндээ талархаж байна

Хүндэтгэсэн,

О. Хүрэлбаатар

Ариг банкны Гүйцэтгэх захирал

Бүтэц, зохион байгуулалт



Удирдлагын баг



О.Хүрэлбаатар

Гүйцэтгэх захирал



Б.Бямбаноров

Бизнес хариуцсан
Дэд захирал

Ш.Энхтөр

Захиргаа, эрх зүйн
газрын захирал



Х.Анхсүрэн

Бизнес банкны
газрын захирал

Э.Ананд

Санхүү удирдлагын
газрын захирал



Б.Оюунцэцэг

Бизнес хөгжлийн
газрын захирал

М.Санчир

Хөрөнгө зохицуулалтын
газрын захирал

Б.Мандуул

Дижитал банкны
газрын захирал



Т.Ган-Эрдэнэ

Эрсдэлийн удирдлагын
газрын захирал

А.Тамир

Мэдээлэл технологийн
газрын захирал

Ж.Мөнх-Итгэлт

Дотоод хяналтын
газрын захирал

Хараат бус аудиторын тайлан

АРИГ БАНК ХХК

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Санхүүгийн Хураангуй Тайлан
2023 оны 12 дугаар сарын 31



Хараат бус аудиторын тайлан



Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia
Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг Банк ХХК -ийн хувьцаа эзэмшигчид

Дүгнэлт

Бид Ариг Банк ХХК ("Банк")-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр дурдсан санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-оос баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартууд ("АОУС")-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлэсэн үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын 8 с зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэисэн нягтлан бодогчдын 8 с зүйн дүрэм"-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад 8 с зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс оор бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг олж ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

Хараат бус аудиторын тайлан



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ариг Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Банкны 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг өөр аудитор гүйцэтгэсэн бөгөөд 2023 оны 4-р сарын 12-ны өдөр тэдгээр санхүүгийн тайлангийн талаар зөрчилгүй дүгнэлтийг гаргасан.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө харьцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Доржбатын Мандахбаяр
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 31

Хараат бус аудиторын тайлан

АРИГ БАНК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	32,435,106	13,672,760
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	4	4,322,457	1,842,620
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(15,419,113)	(3,867,460)
Хүүгийн цэвэр орлого		21,338,450	11,647,920
Хураамж ба шимтгэлийн орлого	6	798,912	398,200
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(498,072)	(244,528)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого		300,840	153,672
Худалдааны болон бусад үйл ажиллагааны орлого	7	5,187,405	4,893,858
Үйл ажиллагааны нийт орлого		5,187,405	4,893,858
Хүлээгдэж буй үнэ цэнгийн бууралтын алдагдлын зардал	8	4,064,892	3,381,152
Үйл ажиллагааны цэвэр орлого		30,891,587	20,076,602
Үйл ажиллагааны зардал	9	(15,663,566)	(11,006,940)
Татварын өмнөх ашиг		15,228,021	9,069,662
Орлогын албан татварын зардал	10	(2,118,006)	(885,970)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого, татварын дараах		13,110,015	8,183,692

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салцгүй нэг хэсэг болно.

Хараат бус аудиторын тайлан

АРИГ БАНК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Санхүүгийн байдлын тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монгол банканд байршуулсан мөнгө	11	60,269,854	48,255,697
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	12	134,074,473	97,805,510
Бодит үнэ цэнийг ашиг, алдагдлаар тооцох санхүүгийн хөрөнгө	13	6,768,086	4,402,477
Бодит үнэ цэнээр бусад дэлгэрэнгүй орлогоор тооцсон өрийн хэрэгсэл	13	-	890,197
Бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлсэн өмчийн хэрэгсэл	13	33,744	33,744
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгсэл	13	25,521,059	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14	192,087,621	101,542,521
Бусад хөрөнгө	15	6,555,380	3,443,945
Одоогийн татварын урьдчилгаа төлбөр	10	221,896	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	10.3	190,940	1,325,653
Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж ба ашиглах эрхтэй хөрөнгө	16	14,914,053	7,807,915
Биет бус хөрөнгө	17	2,244,253	1,118,111
НИЙТ ХӨРӨНГӨ		442,881,359	266,625,770
ӨР ТӨЛБӨР			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	18	138,529,426	90,643,376
Харилцагчдын харилцах, хадгаламж	19	174,739,546	61,872,128
Зээлийн санхүүжилт	20	10,357,209	11,488,146
Бусад өр төлбөр	21	6,876,218	3,148,034
Орлогын татварын өглөг	10.2	-	164,232
Хойшлогдсон татварын өглөг	10.3	-	40,909
НИЙТ ӨР ТӨЛБӨР		330,502,399	167,356,825
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	22	100,033,190	100,033,190
Бусад нөөц сан	22	51,647	7,109,810
Хуримтлагдсан ашиг		12,294,123	(7,874,055)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		112,378,960	99,268,945
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		442,881,359	266,625,770

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

Хараат бус аудиторын тайлан

АРИГ БАНК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Энгийн хувьцаа мян.төг (Тод. 22)	Бусад нөөц мян.төг (Тод. 22)	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2023 оны 1 сарын 1-ний байдлаар	100,033,190	7,109,810	(7,874,055)	99,268,945
Тайлант жилийн ашиг болон бусад дэлгэрэнгүй орлого	-	-	13,110,015	13,110,015
Тусгай зориулалттай нөөцийн хөдөлгөөн*	-	(7,058,163)	7,058,163	-
Энгийн хувьцааны нэмэгдэл	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ний байдлаар	100,033,190	51,647	12,294,123	112,378,960
2022 оны 1 сарын 1-ний байдлаар	50,016,595	6,785,260	(15,733,197)	41,068,658
Тайлант жилийн ашиг болон бусад дэлгэрэнгүй орлого	-	-	8,183,692	8,183,692
Энгийн хувьцааны нэмэгдэл	50,016,595	324,550	(324,550)	50,016,595
2022 оны 12 сарын 31-ний байдлаар	100,033,190	7,109,810	(7,874,055)	99,268,945

*Бусад нөөцөд тусгай зориулалтын нөөц багтсан ба уг нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилах боломжтой.

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

Хараат бус аудиторын тайлан

Хараат бус аудиторын тайлан

АРИГ БАНК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйцээний тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг			
<i>Тохируулгууд:</i>			
	9	(17,283)	133,355
Түрээсийн гэрээ цуцалсны (олз)/гарз		(267,996)	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	7		-
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	9	100,813	-
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны цэвэр гарз, цэвэр	9	48,705	45,755
Эрдэлийн сангийн (буцаалт)/зардал			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	8	42,031	22,633
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	8	558,268	(1,917,732)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	8	(4,723,507)	(1,651,750)
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	8	85,500	-
Бусад хөрөнгө	8	20,662	(18,069)
Тэншлийн гадуурх үүрэг	8	(47,846)	183,766
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	9	2,075,657	1,191,700
Биет бус хөрөнгийн хорогдуулга	9	588,205	178,873
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	9	28,312	12,559
Зээлээр авсан эх үүсвэрийн хүүний зардал	5	360,063	35,382
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		14,079,605	7,286,134
<i>Эргэлтийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		(22,882,359)	(22,195,274)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		35,161,591	(34,783,384)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(85,773,744)	(75,784,940)
Бусад хөрөнгө		(4,993,387)	(1,467,660)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		21,388,772	51,888,954
Харилцагчдын харилцах, хадгаламж		139,364,694	40,659,663
Бусад өр төлбөр		2,964,015	1,438,631
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		99,309,187	(32,957,876)
Орлогын албан татварын төлөлт	10	(1,410,330)	(369,473)
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт		403,640	148,420
Зээлээр авсан эх үүсвэрт төлсөн хүү		(360,063)	(35,382)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		97,942,434	(33,214,311)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт		(28,136,965)	(895,197)
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө худалдан авалт	16	(6,003,279)	(4,498,286)
Биет бус хөрөнгө худалдан авалт	17	(1,815,160)	(813,232)
Үндсэн хөрөнгө борлуулснаас орсон мөнгө		367,886	437,714
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө борлуулснаас орсон мөнгө		190,687	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулснаас орсон мөнгө		13,210,654	23,865,264
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(22,186,177)	18,096,263

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

8

АРИГ БАНК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Мөнгөн гүйцээний тайлан (үргэлжлэл)


	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<i>Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт</i>			
		(1,130,938)	5,442,781
<i>Шинээр гаргасан хувьцаа</i>			
		-	50,016,595
<i>Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт</i>			
		(1,307,007)	(767,237)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан/ ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ		(2,437,945)	54,692,139
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11	73,318,312	39,574,091
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11	80,704,074	41,129,983
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		154,022,386	80,704,074
Хүүтэй холбоотой үйл ажиллагааны мөнгөн урсгал			
Төлөөн хүү		(12,387,406)	(2,720,701)
Хүлээн авсан хүү		33,972,582	14,074,009
Мөнгөн бус үйл ажиллагаанууд			
Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөгийн нэмэгдэл	16	(2,012,436)	(2,081,262)
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт:			
		2023 мян.төг	2022 мян.төг
Түрээсийн өглөг			
1 сарын 1-нээр		1,885,803	575,519
Мөнгөн бус нэмэгдэл		2,012,436	2,081,262
Түрээсийн гэрээ цуцлагдсан түрээснүүд		(123,001)	(169,231)
Тайлант үеийн хүүгийн зардал		403,640	165,491
Түрээсийн өглөгийн хүүгийн төлөлт		(403,640)	(165,491)
Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн төлөлт		(903,367)	(601,747)
12 сарын 31-нээр		2,871,871	1,885,803
Зээлээр авсан санхүүжилт			
1 сарын 1-нээр		11,488,147	6,045,365
Шинээр татсан эх үүсвэр		4,286,124	6,990,549
Эргэн төлөлт		(5,417,062)	(1,547,768)
Хүүгийн төлөлт		(359,134)	(54,933)
Цэвэр эргэн төлөлт		(1,490,072)	5,387,848
Гадаад валютын ханшийн зөрүү		(929)	19,551
Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн бус гүйлгээ		(929)	19,551
Хуримтлагдсан хүү		360,063	35,382
12 сарын 31-нээр		10,357,209	11,488,146

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.


9

2023.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд

НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ



ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР




2023.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд


НИЙТ ХӨРӨНГӨ
(тэрбум төгрөг)




ЦЭВЭР ЗЭЭЛ
(тэрбум төгрөг)




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ
(тэрбум төгрөг)




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ
(тэрбум төгрөг)



ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО
(тэрбум төгрөг)



ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ
(тэрбум төгрөг)



Нийгмийн хариуцлагын ажил



Ариг банк нь нийгмийн хариуцлага болон харилцагчдадаа үзүүлэх үйлчилгээг улам сайжруулах зорилгоор хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

- Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас 2023 оны 06 дугаар сарын 30-наас эхлэн 8 дугаар сарыг дуустал зам тээврийн осол, хэргийн улмаас хуний амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, замын хөдөлгөөний соёлыг төлөвшүүлэх зорилгоор “НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ” нөлөөллийн аяныг зохион байгуулсан бөгөөд энэхүү аяныг Ариг банк 2,500,000 төгрөгөөр ивээн тэтгэж ажиллав
- 2023 оны хувьд Монгол улсын хэмжээнд хэдэн хэдэн үер усны гамшиг тохиолдсон бөгөөд үндэсний их баяр наадмын өмнөхөн Улаанбаатар хотод болсон үер усны гамшигийг даван туулахад зориулж Улсын онцгой комисс 10,000,000 сая төгрөг хандивлаа.
- Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч Ариг банк 2014 онд “Achilles International Mongolia” төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулалцаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор дамжуулан нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулахад хувь нэмрээ оруулахаар ажиллаж эхэлсэн түүхтэй. Энэхүү уламжлалын дагуу 6 удаагаа Ахиллис Монгол интернейшнл ОУБ-тай хамтран “Итгэл найдвар, Боломж” гүйлтийг 2023 оны 09 сарын 18-нд зохион байгуулав.
- Ариг банк нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд тустай ажлуудад идэвх санаачилгатай оролцооор ирсэн билээ. Тэгвэл 2023 онд 2 дах удаагаа “ЦССҮТ”-тэй хамтран цусаа хандивлах өдрийг нийт 200 гаруй ажилтныхаа дунд зохион байгууллаа.
- Банкны нийт ажилтнуудынхаа дунд зохион



- байгуулж ирсэн “Өгөх өдөр” арга хэмжээг 2 дах жилдээ зохион байгуулж цугласан бэлэг, номыг хүүхдийн баярыг угтан Улаанчулуудад байрлах “Вэлүү” сангийн дэргэдэх “Нарны хүүхдүүд” цэцэрлэгийн хүүхдүүдэд бэлэглэлээ. Мөн эх үрсийн баярыг тохиолдуулан тус цэцэрлэгээс цэцэрлэгийнхээ хүүхдүүд болон тэр хэсгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан хүүхдийн баярын өдөрлөгт нийт 200 гаруй хүүхдийг бэлэг тарааж, хүүхдийн баатруудыг тоглолтыг толилуулсан юм.
- Ариг банк нь Монголын банкны холбооны гишүүн байгууллагын хувьд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийгмийн хариуцлагын дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мод тарих” өдөрлөгийг Маркетингийн хэлтсээс зохион байгуулж

- өөрийн төгөлдөө 100 гаруй модыг шинээр нэмж тариалаа.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн сайн сайхны төлөө Сүхбаатар дүүргийн 100 хүүхдэд хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан хадгаламжийн дэвтэр гарын бэлгийн хамт бэлэглэлээ.
- “Ахиллис Монгол” ОУ байгууллагатай хамтран хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл чийрэг иргэний бий болгох үүднээс “Багачуудын хөгжилтэй гүйлт-2023” арга хэмжээг /2023.05.21/ зохион байгууллаа.
- Оюунлаг залуусыг дэмжих зорилгоор Роял ОУ-ын сургуулиас зохион байгуулсан “Хөгжлийн ирээдүй- Оюунлаг залуус” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг Ариг банк ивээн тэтгэж ажиллалаа.

Онцлох үйл явдлууд 2023



Ариг банк Жижиг, дунд худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин сар шинийн баярыг тохиолдуулан “Амар байна уу – 2023” үзэсгэлэнд оролцлоо.



Ариг банк үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ санхүү тайлагналын **олон улсын стандартын дагуу иж бүрэн санхүүгийн тайлангаа бэлтгэлээ**. Тус Санхүү тайлагналын олон улсын стандарт 9 буюу Санхүүгийн хэрэглүүр стандартыг “Прайсвотэрхаус Күүперс Эдвайзори” ХХК (PwC)-иас зөвлөх үйлчилгээ авч амжилттай нэвтрүүлсэн юм.



Ариг банк өөрийн хугацаатай хадгаламж эзэмшигчдийн дундаас 100,000,000 сая төгрөгийн урамшууллын эзэн тодруулах “Аригтай хадгалъя” хадгаламжийн урамшуулалт аяныг анх удаа зарлаж амжилттай зохион байгууллаа.



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкууд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 50 сая мод тарихаар зорьж байна. Тус зорилтын дагуу хаврын мод тарих улирал эхэлсэнтэй холбогдуулан сүүлийн 3 жилийн хугацаанд өөрсдийн төглийг бий болгохоор мод тарьж байгаа Ариг банкныхан 2023 оны 05 сарын 17-нд ээлжит модоо тарилаа. Ариг банкны ажилтнууд өнгөрсөн хугацаанд **200 гаруй мод сөөг тарьж ургуулаад байна**.



Монгол Улсын банк санхүүгийн салбарт 26 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж буй дотоодын 100 хувь хөрөнгө оруулалттай Ариг банк нь түүхэндээ анх удаагаа **“Монгол Улсын ТОП-100 аж ахуй нэгж”**-ийн нэгээр шалгарлаа. Ариг банканд өндөр итгэл үзүүлэн санхүүгийн үйлчилгээгээ даатгах харилцагчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдэхийн зэрэгцээ Ариг банкны санхүүгийн шалгуур үзүүлэлт сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж банкны системд эзлэх байр суурь тэлж, найдвартай байдал нэмэгдэж байгаагийн тод илрэл нь **“Монгол Улсын Топ-100 аж ахуй нэгж”**-д шалгарсан явдал байлаа.



Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч “Ариг банк” нийгмийн сайн сайхны төлөө жил бүр ажилтнуудынхаа дунд “Өгөх өдөр” –ийг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жилийн “Өгөх өдөр”-ийг СХД-ийн 26-р хороо, Улаанчулуутад байрлах “Вэлүү сан” ТББ-ийн дэргэдэх “Нарны хүүхдүүд” цэцэрлэгтэй хамтран ажиллалаа. Тус цэцэрлэгээс Эх үрсийн баярыг тохиолдуулан өөрийн цэцэрлэгийн болон ойр орчмын хүүхдүүдийг баярлуулахаар 2023 оны 05 сарын 26-нд зохион байгуулсан баярт Ариг банкнаас “Өгөх өдөр”-ийн хүрээнд бүрдүүлсэн **140 гаруй бэлгийг** цэцэрлэгийн бүх бүлгийн хүүхдүүдэд бэлэглэлээ.



Ариг банк **Дархан салбарын байраа шинэчиллээ**. Ариг банкны Дархан салбар 1999 оноос Дархан Уул аймагт үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй. Харин өнөөдөр Ариг банк тус аймагт 3-н салбар тооцооны төвөөрөө дамжуулан санхүүгийн үйлчилгээгээ хүргэж байгаа бөгөөд ийнхүү “Номин” худалдааны төвд салбарын байраа шилжүүлэн үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.



Ариг банк ХХК нь Монголбанкнаас **хаалттай хувьцаат компани болж** хэлбэрээ өөрчлөх зөвшөөрлөө авлаа. Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төлөвлөгөө хүргүүлэх, тайлагнах, хянах журам”-д заасны дагуу банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна гэсэн. “Ариг банк” ХХК нь тус зохицуулалтын дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд банкныг хаалттай хувьцаа компани хэлбэрээр өөрчлөн байгуулах зөвшөөрлөө Монголбанкнаас авлаа. Ингэснээр банкны засаглал сайжирч, үйл ажиллагаа илүү ил тод болох нөхцөл бүрдэж байгаа юм.



Онлайн цалингийн зээлийг нэвтрүүлээ. Ариг банкнаас өөрийн харилцагч төдийгүй бусад банкны харилцагчдын үнэт цагийг нь хэмнэж, амар хялбар бас шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор **НЭГХЭН МИНУТАД ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ** авах боломжтой Ариг онлайн үйлчилгээг шинээр нэвтрүүлээ.



Ариг банкны хамт олон **дахин цусаа хандивлалаа**. Ариг банк нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд тустай ажлуудад идэвх санаачилгатай оролцоор ирсэн билээ. Тэгвэл энэ удаад “ЦССҮТ”-тэй хамтран хоёр дахь удаагаа цусаа хандивлах өдрийг нийт 200 гаруй ажилтныхаа дунд зохион байгууллаа.



“Итгэл, найдвар, боломж-УБ” бүх нийтийн марафоныг хамтран зохион байгууллаа. “Ахилис Монгол” ОУБ, Ариг банк хамтран зохион байгуулсан “Итгэл, найдвар, боломж-УБ” бүх нийтийн марафон гүйлтийн арга хэмжээ 2023 оны 09-р сарын 16-ны өдөр Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнд амжилттай болж өндөрлөлөө. 2015 оноос хойш жил бүрийн 9-р сард зохион байгуулдаг “Итгэл, найдвар, боломж” бүх нийтийн гүйлт нь олон нийтийг спортод хамруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг хөгжүүлж, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлж, амьдралын чанарыг нь дээшлүүлэх зорилготой юм.



Ариг банкны **шинэ салбар “Централ Молл”-д нээгдлээ**. Ариг банкныг сонгон үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хирээр банкны үйлчилгээг улам ойртуулах үүднээс Ариг банк Улаанбаатар хотын зүүн хэсэг зүүн 4 замын “Central Mall” худалдааны төвд шинэ салбараа нээлээ.



Ариг банк “Их хуралдай” оффист шинэ салбараа нээлээ. Харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэхээр Ариг банк Энхтайваны гүүрний баруун урд, “Их хуралдай” оффисын хоёрдугаар давхарт шинэ салбараа нээлээ.



Ариг банк “Номин” их дэлгүүрт шинэ салбараа нээлээ. Харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэхээр Ариг банк Баянгол дүүрэгт “Номин” их дэлгүүрийн нэгдүгээрт давхарт шинэ салбараа нээлээ.




Ариг банк Орхон аймагт салбараа нээлээ. Харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэхээр Ариг банк Орхон аймгийн Баян-Өндөр сумын Үйлчилгээний төвд шинэ салбараа нээлээ. Ингэснээр төвийн бүсийн аймгийн харилцагчид Ариг банкаар үйлчлүүлэх боломж бүрдэж байгаа юм.



Ариг банкны нийт актив хөрөнгө өмнөх оны мөн үеэс **169%-иар өсгөж**, 2023 онд 440 тэрбум төгрөгт хүрлээ.

ДИЖИТАЛ БАНК



Худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох зорилтын хүрээнд харилцагчдын цагийг хэмнэсэн, технологийн дэвшилд тулгуурласан олон төрлийн цахим бүтээгдэхүүнийг гаргалаа.



Төлбөрийн карт:

- Дотоодын ₮ карт болон байгууллагуудтай хамтарсан картыг шинэ дизайн, шинэ үйлчилгээний нөхцөлтэйгөөр зах зээлд гаргаж эхлэв.
- Байгууллагын бизнес дебит, кредит карт
- Visa кредит олон улсын эрхтэй карт



- Төлбөрийн картыг эрсдэлээс хамгаалах "VISA RISK MANAGER" программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

Пос терминал:

Посын үйлчилгээндээ Андроид үйлдлийн системтэй төхөөрөмжийг шинээр нэвтрүүлж үйл ажиллагаагаа тэлсээр байна. НӨАТ-н баримт хэвлэх боломжтой Пос терминалын үйлчилгээ.

Интернэт банк:

Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, зах зээлд өрсөлдөхүйц "АРИГ ОНЛАЙН" цахим банкны аппликейшнийг зах зээлд шинээр гаргав. Харилцагч Ариг онлайн аппликейшнийг ашиглан дараах үйлчилгээнүүдийг хамгийн хямдаар, хялбараар гүйцэтгэх боломжтой юм. Үүнд:

- Бүх төрлийн шилжүүлэг
- Зээл
- Төлбөр төлөлт
- Гааль, татвар
- QR төлбөр тооцоо
- Бэлэн мөнгө авах
- E-shop үйлчилгээ

Хүний нөөцийн үйл ажиллагаа

Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй.

Баг, хамт олон, бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.


Бидний үнэт зүйлсээс...

Банкны 2023 оны хүний нөөцийн зардлын төсөв, бүтэц, зохион байгуулалт, орон тоог Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Газар, нэгжид шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж бэхжүүлэх, хүний нөөцийн эргэцийг зохих түвшинд байлгах ажлын хүрээнд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар 133 ажилтан ажилд томилогдож, 53 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна. Банкны хүний нөөцийн эргэц 19,6% буюу зохист түвшинд байна.

“Ариг банкны хөдөлмөрийн дотоод журам”, “Ариг банкны ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх журам”, “Ариг банкны ажилтанд олгох зээлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан батлуулж, журмын хэрэгжилтийг хангаж байна. Ариг банкны Хүний нөөцийн бодлогыг шинэчлэн боловсруулж, Удирдлагын хороогоор хэлэлцүүлж, ТУЗ-н дэргэдэх Цалин урамшууллын хороонд танилцуулсан бөгөөд ТУЗ-д танилцуулж, батлуулахаар хүлээгдэж байна.

Банкны Салбарын удирдлагын хэлтэс, салбар, тооцооны төвийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх үзүүлэлт (KPI)-ийг албан тушаал бүрээр шинэчлэн тодорхойлж, баталгаажуулсан байна.

2023 оны сургалтын батлагдсан төсвийн хүрээнд банкны дотоодод зохион байгуулсан 108 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 656 ажилтан, Банк санхүүгийн академи болон бусад мэргэжлийн байгуулагаас зохион байгуулсан 72 сургалтанд 583 ажилтан тус тус хамрагдсан. Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтын цогц хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.



Ажилтны цалин хөлс болон ажилтнуудтай хамааралтай санхүү бүртгэлийн ажиллагаа, тайланг хууль журмын дагуу гүйцэтгэж, ажилтанд олгох зээлийн багцын хэмжээг зохих түвшинд барих, зээлийн чанарын ангилалыг бууруулахгүй байхад анхаарч ажиллалаа. 2023 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 71 ажилтанд 1233,8 сая төгрөгийн цалин барьцаалсан зээл, 7 ажилтанд 1037,7 сая төгрөгийн орон сууцны зээл, 3 ажилтанд 16,4 сая төгрөгийн кредит картын зээл олгосон байна.

Нийт ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулах тэдгээрийг эрүүл байдлаар ажлаа хийж гүйцэтгэх, ажлын хариуцлагын зохистой харьцааг хангах, ажлын гүйцэтгэлтэйгээ нийцсэн цалин орлоготой байх нөхцлийг хангах үүднээс банкны нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулав.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар Гүйцэтгэх захирлын 739 тушаал батлагдаж, нийт 20 заавар, журмыг шинээр боловсруулж, 38 заавар журамд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж хэрэгжүүлж байна.

Тус банкинд ирсэн 837 албан бичгийг бүртгэж, холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд 1,210 албан бичгийг төлөвлөж, баталгаажуулан гадны байгууллагад хүргүүлсэн. Дансны мэдээлэл авах, данс битүүмжлэх, чөлөөлөх тухай ирсэн 9,943 бичгийг хүлээн авч, 2,184 лавлагаа гаргаж явуулсан байна.

Гүйцэтгэх захирлын дэргэдэх 6 хороо нийт 287 удаа хуралдаж 678 асуудал шийдвэрлэсэн, тухайлбал Удирдлагын хороо 37 удаа хуралдаж 123 асуудал, Гүйцэтгэгч сонгон шалгаруулах хороо 16 удаа хуралдаж 35 асуудал, Зээлийн хороо 69 удаа хуралдаж 135 зээлийн асуудал, Зээлийн дэд хороо 92 удаа хуралдаж 297 зээлийн асуудал, Эрсдэлийн ерөнхий хороо 17 удаа хуралдаж 33 зээлийн асуудал, Актив, пассивын хороо 8 удаа хуралдаж 16 асуудал тус тус хэлэлцэж шийдвэрлэжээ. Мөн Хугацаа хэтэрсэн зээлтэй ажиллах хороо 39 удаа хуралдаж банкны салбар тооцооны төвийн чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлдэгчийн асуудлыг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргажээ.



Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ



Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд шинээр нэвтрүүллээ. Үүнд:

- Харилцагчид хуримтлах дадлыг бий болгох зорилготой, өндөр хүүтэй, олон талын өгөөжтэй “Хуримтлалын үндэс” хадгаламж
- Барилгын компаниудын борлуулалтыг дэмжих зорилготой Орон сууцны борлуулалтын хадгаламж болон зээлийн үйлчилгээ
- Алтны бизнес эрхлэгчдэд зориулсан Алт барьцаалсан зээл, Биет алтны арилжааны бүтээгдэхүүн
- Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан эргэлтийн хөрөнгийн зээл
- Монгол банк, Засгийн газар, Сангийн яам, Хөдөө

аж ахуйн яамтай хамтран хэрэгжүүлэх хүүгийн хөнгөлөлтэй нөхцөл бүхий Хөдөө аж ахуйн зээл, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжид олгох зээл

- Богино хугацаанд бизнесийн эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх зорилготой иргэдэд зориулсан Авто машин барьцаалсан шуурхай зээл
- Нийлүүлэлтийн сүлжээний бизнес эрхлэгчдийн

санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой Ханган нийлүүлэгчийн багц бүтээгдэхүүн

- Түүнчлэн зах зээл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, техник технологийн өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн нөхцлийг сайжруулан харилцагчдадаа санал болгон ажиллалаа. Үүнд.
- Хадгаламжийн сертификатын бүтээгдэхүүний журам, нөхцөл, харилцагчтай байгуулах гэрээ, сертификатын загварыг шинэчлэв.
- Энгийн хугацаатай хадгаламжийг хоногийн хугацаатай болгон бүтээгдэхүүнийг шинэчилж, харилцах дансны хүүг шинэчлэн тогтоов.
- Эргэлтийн хөрөнгийн зээл, Орон сууц барьцаалсан шуурхай зээл, ПОС-ын орлого барьцаалсан зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоож зээлийн хугацааг уртасгав.
- Орон сууц, амины орон сууц, хашаа байшин худалдан авах, барих зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулж, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээг зээлийн хүүтэй уялдууж уян хатан нөхцөлтэй болгов.
- Ам.долларын хугацаатай хадгаламжийн хүүг шинэчлэн тогтоов.
- Зээлийн үйлчилгээний шимтгэл хураамжийн хувь хэмжээг боломжит түвшинд бууруулж, дээд хязгаарыг тогтоов.

Тайлант хугацаанд Хадгаламж эзэмшигч харилцагчдынхаа дунд 100.0 сая төгрөгийн супер шагналтай урамшуулалт, сугалаат аяныг амжилттай зохион байгуулсанаар нийт хугацаатай хадгаламжийн дүн болон харилцагчдын тоог өмнөх оноос 3,2 дахин өсгөлөө.

Цаашид банк нь Худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох зорилтынхоо хүрээнд худалдааны салбарын бизнес эрхлэгчдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, банкны үнэнч харилцагч нартаа зориулсан Лоялты хөтөлбөр бүхий хөнгөлөлт урамшууллын үйлчилгээг санал болгохоор ажиллаж байна.



Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагын бүтэц нь 4 түвшинд хуваагдана.

1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороо /ТУЗ-н ЭУХ/: Эрсдэлийн удирдлагын баримтлах стратеги, бодлого болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах.

2 Банкны Эрсдэлийн Хороо /ЭХ/ нь банкны эрсдэлийн бодлого, үйл ажиллагаа нь банкны үндсэн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, түүний хэрэгжилтийг ТУЗ-ийн ЭУХ-д тайлагнах банкны гол эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авах, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам зааврыг батлах, эрсдэлийн соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хамаарна.

3 Эрсдэл хариуцсан нэгж болох Эрсдэлийн удирдлагын газар, Дотоод хяналтын газар. нь эрсдэлийн бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, мөн банкны үйл ажиллагааг дэмжих болон удирдах нэгжүүд, бизнес нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагад оролцогчдыг холбох, эрсдэлийн нэгдсэн мэдээллээр хангах, банкны эрсдэлийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажиллагааг хариуцна.

4 Салбар, тооцооны төв нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь банкны эрсдэлийн бодлогыг тодорхойлох, бодлогоор заасан хэм хэмжээний хүрээнд, банканд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой түвшин хүртэл бууруулах зорилгын хүрээнд банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, засаглалыг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих болон түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулах, олон улсын жишиг, сайн туршлагад үндэслэж тогтмол хөгжүүлэх, сайжруулахад оршино.

Эрсдэлийн удирдлагын газар нь банкны эрсдэлийн удирдлага, журмын хэрэгжилтийг хангаж банканд учирч болзошгүй бүх төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдэлийг

хэмжих, үнэлэх, бууруулах арга замыг тодорхойлох ажлыг удирдан зохион байгуулах замаар банкны эрсдэлийг зохистой хэмжээнд байлгах, банкны үйл ажиллагааны найдвартай байдлыг хангаж үр ашгийг дээшлүүлэхээр ажиллаж байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн чиг үүрэг нь банкны зээлийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, зээлийн багцын удирдлагыг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээлэх, дохиолох, эрсдэлийг удирдах, учирч болзошгүй хохирлыг зохистой түвшинд барих, олгосон зээлийг хугацаа хэтрэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээг бууруулах арга замыг

эрэлхийлэх, хэрэгжүүлэх, зээл олголтын дараах гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.

Банк нь зээлийн эрсдэлийг зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс шалтгаалж үүсэх алдагдлыг зээлийн эрсдэл гэж тодорхойлдог. Түүнчлэн энэ эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн эрсдэлийн удирдлага болон хяналтын арга замуудыг зээлийн үйл ажиллагааны журам, заавруудаар зохицуулахаас гадна Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэн ажиллаж байна.

Ариг банк нь зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны бизнесийн стратеги зорилтуудтай нийцүүлэхээс гадна олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн зээлийн багцын чанарт үнэлгээ хийх, хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тодорхойлох, төвлөрлийн эрсдэлийг үнэлэх, хязгаарлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэлийн удирдлага нь нийгэм, эдийн засгийн голлох хүчин зүйлс өөрчлөгдсөний улмаас банканд шууд болон шууд бусаар алдагдал бий болж болзошгүй эрсдэлүүдийг ойлгох бөгөөд тэдгээрээс урьдчилан сэргийлэх, банканд үзүүлэх нөлөөг бууруулах зорилгоор удирдлагыг мэдээллээр хангах, дохиолох чиг үүргийг хэрэгжүүлж, банкны зах зээлийн эрсдэлийг зохих түвшинд барин ажиллана.

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах эрсдэлүүдийг нэгтгэн удирддаг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор Монголбанкнаас тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицын хязгаарлалтуудыг хангахын зэрэгцээ “Хамгийн их эрсдэлийн арга”-аар

эрсдэлийг сар бүр тогтмол хэмжин, удирдан ажиллаж байна.

Хүүгийн эрсдэл

Зах зээл дэх хүүгийн түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд нөлөөлдөг. Банк нь банкны хяналт, шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүгийн түвшний стандарт болон шокийн сценарио хувилбаруудыг ашиглан хүүгийн түвшний эрсдэлийг хэмжиж, лимит тогтоох замаар сөрөг нөлөөллийг хязгаарлан ажиллаж байна.

Зах зээлийн төлөв байдлын буюу зах зээлийн дохиологч хүчин зүйлс

Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож, түүнийг



тэсвэрлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадварыг хадгалах, шаардлагатай нэмэлт нөөцийг хэрхэн бүрдүүлэх болон эрсдэлийн түвшнийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн стресс тестийн шинжилгээг тогтмол хийн ажиллаж байна.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Банк нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зорилгоор хөрвөх чадварын түвшнийг найдвартай хэмжих, хянах, удирдах, тайлагнах зорилго бүхий мэдээллийг банкны удирдлага болон холбогдох ажилтнуудад тогтмол танилцуулан ажиллаж байна. Мөн банкны урт болон богино хугацааны төлбөрийн чадварыг зохистой түвшинд удирдах, Монголбанкны зохистой харьцаа болон Базелийн хорооны стандартын жишиг үзүүлэлтүүд болох LCR, NSFR харьцаа үзүүлэлтийг тогтмол хэмжин, сар, улирлын давтамжтай холбогдох удирдлагуудад тайлагнан ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэл нь банкны нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой удирдаж хянах үүднээс үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журмын дагуу учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, банкны эрсдэлийн нэгдсэн самбарын бүртгэлийг хөтлөх, эрсдэлийн бүртгэлд хяналт тавих, ТУЗ, удирдлага болон холбогдох ажилтнуудыг мэдээллээр хангах, дохиолох, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих зэрэг эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын газар нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ банкны нэгжүүдийн үйл ажиллагаанд үүссэн аливаа эрсдэлийг хянах, урьдчилан сэргийлэх, дохиолох ажлыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэдэг. Үйл

ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкны үйл ажиллагаанд мөрдөж журам зааврыг боловсруулах явц, шинээр нэвтрүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлд эрсдэл үүсэж болзошгүй талаар үнэлэлт дүгнэлт өгч ажилладаг. Эрсдэлийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх цаашлаад үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог ахисан түвшинд хүргэх зорилгоор банк нь олон улсад ашиглагдаж буй үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын арга аргачлалыг нэвтрүүлэн эрсдэлийн үйл ажиллагааны соёлыг бий болгохоор зорин ажиллаж байна.

Мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлага

Мэдээлэл технологийн эрсдэл нь мэдээлэл технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хянах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад оршино. Тус банк нь үйл ажиллагаандаа мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын ISO/IEC27005 стандарт, Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журмыг мөрдлөг болгон ажилладаг.

Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, зөрчил илэрсэн тухай бүрд эрсдэлийн түвшнийг хүлээн зөвшөөрч болох доод түвшинд бууруулах, шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч, эрсдэлийн самбарт тухай бүр бүртгэн нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эрсдэлийн тохиолдол бүрд арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын газар нь мэдээлэл технологийн эрсдэлийн удирдлагын хүрээнд мэдээлэл технологийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, үр дүн, тайлан, түүний үнэлгээг Мэдээлэл технологийн хороонд танилцуулан ажиллаж байна.

Олон улсын харилцааны чиглэлээр

Ариг банк 2023 онд корреспондент данс нээх, зээлийн шугам батлуулах, гадаад эх үүсвэр татах чиглэлүүдээр Сингапур, Швейцарь, Тайвань, ХБНГУ, Япон, БНСУ, Австри, Их Британи, Австрали, БНХАУ, Польш, БНКУ зэрэг улсуудын 50+ банк, санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоон, гадаад харилцаагаа өргөжүүлэн ажиллалаа.

Корреспондент данс нээх чиглэлээр ХБНГУ-ын Bayerische Landes банкинд еврогийн, БНХАУ-ын Bank of Inner Mongolia банкинд ам.доллар, юанийн данс нээж, харилцагчийн гадаад төлбөр, тооцоог дамжуулж эхэллээ.

Ариг банкны вэб хуудаст Комплаенс болон Корреспондент харилцаанд баримтлах зарчмуудыг нийтлэж, Олон улсын МУТСТ хууль журмыг баримтлан ажиллахаа тунхаглав.

Гадаад төлбөр, тооцооны SWIFT программын Transaction Screening Service үйлчилгээг суурилуулан, банкны гадаад гүйлгээг, Олон улсын хориг жагсаалтын хяналтыг real-time гүйцэтгэн, банкны МУТСТ хяналтыг олон улсын стандартын дагуу хийх боломжтой боллоо.

Мөн банк Монгол Банкнаас зохион байгуулсан “БНХАУ-Монгол улсын төв банк болон арилжааны банкуудын 9 дэх удаагийн дугуй ширээний уулзалт”, ToC холбооноос зохион байгуулсан “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023” болон бусад арга хэмжээнд оролцож, эдгээр үйл ажиллагаанаас дэвжүүлсэн санал, санаачлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа.



Салбар нэгжийн мэдээлэл

Ариг банк нь Улаанбаатар хот болон Дархан, Эрдэнэт хотуудад нийтдээ 17 салбар нэгж болон хувийн банкны төвөөрөө дамжуулан банкныхаа олон төрлийн үйлчилгээг харилцагчийн тав тух хангасан орчинд, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүргэж ажилласнаас гадна банкны зүгээс салбар нэгжүүдийнхээ өнгө төрх, тохижилтыг шат дараатайгаар шинэчилж ажиллаж байна.

Дээрх бодлогын хүрээнд, бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 365 хоногийн турш тасралтгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор, Ариг банк нь Улаанбаатар хотын төв цэгт байрлах Улсын их дэлгүүрт салбараа нээн, Дөчин мянгат салбарынхаа өнгөр төрх, байршлыг сайжрууллаа.


Мөн Дархан-Уул аймаг дахь харилцагчиддаа зориулж, Дархан салбарынхаа үйлчилгээний танхимын зай талбайг нэмэгдүүлж, “Дархан зах” худалдааны төвд байршлыг шилжүүлснээс гадна анх удаагаа Орхон аймгийн Эрдэнэт хотод шинэ салбараа нээж Эрдэнэтийн харилцагч нартаа банкныхаа үйлчилгээгээ ойртууллаа.

Ариг банк нь шинэ бизнес стратегийн хүрээнд харилцагч төвтэй үйлчилгээний шинэ стандарт, бизнес загварыг боловсруулж, Нийслэл болон орон нутагт хүн ам олноор төвлөрсөн байршилд шинэ салбар нэгжийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх бодлого баримтлан, нэгдсэн стандартын тохижилт бүхий ая тухтай орчинд банкны үйлчилгээг өндөр түвшинд хүргэж, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлж ажиллахыг зорьж байна.

Ариг банкны Хувийн банкны төвийн мэргэшсэн ажилтнууд нь өндөр орлоготой, нэр хүндтэй иргэд, байгууллагуудад тэдний хэрэгцээ, таашаалд бүрэн нийцсэн санхүүгийн үйлчилгээг тав тухтай, найрсаг орчинд 24 цагийн турш тасралтгүй, орон зайг үл харгалзан хүргэж байна. Цаашид өсөн нэмэгдэж буй энэхүү үйлчилгээг харилцагчдад илүү ойртуулах, хөгжүүлэх чиглэлд бид зорин ажиллаж байна.





 arigbank.mn |  7070 1001 |  [arigbank](https://www.facebook.com/arigbank)

“Их Хуралдай” бизнес төв, 13/14 давхар
Чингисийн өргөн чөлөө, 19-р хороолол, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот - 17030